

## "МОНИНЖБАР" ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бид 2020 онд "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метрийн урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аас 1570 метр шугам хоолойн угсралт суурилуулалтыг, түншлэлийн хүрээнд нийт 3170 метрийг хийж гүйцэтгэн, байгаль орчны техникийн нөхөн сэргээлтийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ЦУХ-ийн 3 барилгын угсралтын ажлыг инженер техникийн 8 ажилтан, операторчин жолооч -5, үндсэн 8, туслах 4, нийт 31 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Төслийн ажилд шаардлагатай ган хаалт, ган холбох хэрэгслүүдийг БНХАУ-ын улсын үйлдвэрт захиалан үйлдвэрлүүлж, тээвэрлэн авчирч цэвэр усны 8 худгийн холбох хэрэгслийг бүрэн угсарч туршилт тохируулга хийхэд бэлэн боллоо.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ хууль эрх зүйн акт, дүрэм, журмыг үндэслэл болгон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн барилгын талбайн аюулгүй ажиллагааг ханган ажиллаж ирсэн бөгөөд "Амар даатгал" ХХК-тай 2020 оны 03 дүгээр сарын 31-ны өдөр байгуулсан №ДГ-007-2020 дугаар даатгалын гэрээний үндсэн дээр хамтран ажилласан.

Ажлын талбай дээр 2 удаагийн аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулж инженер техникийн болон туслах ажлчдыг зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжөөр ханган ажилласан.

Ажлын явцад хүндрэл бэрхшээлүүд гарч байсан хэдий ч цаг алдахгүйгээр хариуцсан 3 дүүргийг хамарсан 30 гаруй төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, асуудлыг газар дээр нь шуурхай зохион байгуулж ирлээ.

Зургийн дагуу авто зам дээгүүр ажил гүйцэтгэж байгаа нь цаг хугацаа, тодорхой шийдвэрийн хүрээнд ихээхэн хүндрэл, бэрхшээлийг үүсгэж, төслийн ажлын явцад нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Мөн дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын улмаас Монгол улс түүхэндээ анх удаа бүх нийтийн гамшгийн бэлэн байдлын зэрэг тогтоосон зэрэг нь цаг хугацааны хувьд нөлөөлсөн.

Цаашид төслийн ажлыг 3,4-р хорооллын усан сангаас баруун дүүргийн насос станц хүртэл угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгөх зорилготой ажиллаж байна.

.....000.....

## “МОНИНЖБАР” ХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Манай компани 2020 онд АХБ, ЕХОБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3.4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил”-ыг үргэлжлүүлэн гүйцэтгэлээ.

Энэхүү төслийн ажлын хүрээнд 2020 онд 1 780.3 төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, хамтрагч "Н Эй Би" ХХК-тай гүйцэтгэлийн хувиар ноогдох санхүүжилтийг авсан.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр 1 309.6 сая төгрөгийн борлуулалт, бусад орлого 200.8 сая төгрөг, 809.5 сая төгрөгийн зардал гарган 194.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант хугацааны борлуулалтын орлого нь өмнөх оныхтой харьцуулахад 1 228.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зардал өмнөх оныхтой харьцуулахад 107.3 сая төгрөгөөр буурсан. Тайлант жилд гарсан үйл ажиллагааны зардлыг дотор нь ангилж үзвэл 132.0 сая төгрөг цалин хөлс, 15.6 сая төгрөг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 472.5 сая төгрөг зээлийн хүүгийн зардал, 11.2 сая төгрөг засвар үйлчилгээний зардал, 6.4 сая төгрөг шуудан холбооны зардал, 4.4 сая төгрөг ашиглалтын зардал, 18,7 сая төгрөг түрээсийн зардал, 102.5 сая төгрөг элэгдлийн зардал, 31.5 сая төгрөг бусад зардал тус тус эзэлж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 752,8 сая төгрөгийн хөрөнгөтэй байгаагаас эргэлтийн хөрөнгө 3 790.2 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 79.7%-ийг, эргэлтийн бус хөрөнгө 882.6 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 20.3% -ийг тус тус эзэлж байна.

Мөн оны жилийн эцсийн байдлаар нийт 4 752.8 сая төгрөгийн эх үүсвэртэйгээс нийт өр төлбөр 3 224.8 сая төгрөг буюу эх үүсвэрийн 67.85% -ийг, эзэмшигчийн өмч 1 448.0 сая төгрөг буюу эх үүсвэрийн 32.15 %-ийг тус тус эзэлж байна. Өр төлбөрийн 31.64% буюу 1020.3 сая төгрөгийг дансны өглөг, 2.3% хувь буюу 75.2 сая төгрөгийг цалингийн өглөг, 3.3% буюу 105.8 сая төгрөгийг татварын өр, 2,7% буюу 88,6 сая төгрөгийг татварын алданги торгуулийн өглөг, 0.2%-ийг буюу 6.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр, 54.6%-ийг буюу 1 760.5 сая төгрөгийг банкны зээлийн өр тус тус эзэлж байна.

Өмнөх оны өр төлбөртэй харьцуулахад дансны өглөг өссөн байгаа нь харьяа татварын байгууллагаас “2014-2018 онуудад хамаарах баримтын шалгалт”-аар тогтоосон акт, торгууль НӨАТатварын өр өссөнтэй холбоотой.

Тайлант жилд бид НДШ-53.2 сая, ХАОАТ-т -5.0 сая, Үл хөдлөх хөрөнгийн татварт-1.6 сая, газрын төлбөрт 4.2 сая, авто тээвэрт-0.6 сая төгрөг тус тус нийтдээ 64.6 сая төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээд байна.